

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХАМТАРСАН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 29/17

Улаанбаатар
хот

“Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа
нэвтрүүлэх, хяналт тавих журам”
батлах тухай

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.17, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 12 дугаар зүйлийн 12.3, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тус журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Б.Балгансүрэн/-нд даалгасугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2012 оны 56/38 тоот хамтарсан тогтоол, 2013 оны 18/19 тоот хамтарсан тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА:

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Ц.БОЛДСАЙХАН

ДАРГА:

Б.БАЛГАНСҮРЭН

ГИШҮҮД:

Д.АМГАЛАНБААТАР

Н.БАТТОГТОХ

Ч.ДАВААЖАМЦ

Ц.ЖАДАМБАА

Б.МӨНХБАТ

Р.ОТГОНТУЛГА

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Олон нийтийн радио, телевиз болон бусад өргөн нэвтрүүлэгийн радио, телевизээр (цаашид “радио, телевиз” гэх) сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Олон нийтийн радио, телевиз болон бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхэд Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавина.
- 1.3. Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт заасан өргөн нэвтрүүлэгийн радио, телевизэд Олон нийтийн радио, телевиз болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлэгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй радио, телевиз хамаарна.
- 1.4. Радио, телевиз нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг (цаашид “сонгуулийн сурталчилгаа” гэх) нэвтрүүлэхдээ Сонгуулийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх баримтлах зарчим

- 2.1. Телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхдээ тухайн сурталчилгааны агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран дуу, дүрс авиа, тайлбар зэргийг ашиглан сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлж буй гэдгээ ойлгомжтой тодорхой гаргаж, төлбөртэй гэж тодотгон, тухайн сурталчилгааны нэвтрүүлэгийн нийт хугацааны туршид тухайн нэвтрүүлэгийг захиалсан нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичиж, нэвтрүүлэх бөгөөд энэ нь радиогийн нэвтрүүлэгийн тухайд эхлэл, төгсгөлд хамаарна.
- 2.2. Сонгуулийн сурталчилгааг улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаарх тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг,

боловсролын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур нэвтрүүлэхийг хориглоно.

- 2.3. Сонгуулийн үйл явдлын тухай мэдээ, сурвалжлага, сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.15-д заасан нэвтрүүлэг, сонгуулийн тухай хуулийг олон нийтэд тайлбарласан мэдээлэл, сурталчилгаа, сонгуулийн байгууллагын албан ёсны мэдээллийг сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулахгүй.
- 2.4. Радио, телевиз нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж түгээх үүрэгтэй.

Гурав. Сонгуулийн сурталчилгааг телевиз, радиоогоор нэвтрүүлэх

- 3.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 1.3-т заасан өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн жагсаалтыг энэ журмын хавсралтын дагуу гаргаж, санал авах өдрөөс 45 хоногоос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.
- 3.2. Сонгуулийн ерөнхий хороо болон аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 82.8, 82.9-д заасны дагуу сонгуулийн байгууллагад сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдлийг бусад баримтын хамт ирүүлж, хянуулсан радио, телевизийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх хуваарийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 2-оос доошгүй ажлын өдрийн өмнө хүргүүлнэ.
- 3.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 3.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо болон аймгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулан нийтэд ил тод мэдээлнэ.
- 3.4. Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахдаа Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.3, 82.13, 82.16 дахь заалтад заасан зарчмыг баримтлан нэг нам, эвсэл, нэр дэвшигч бүрд ижил нөхцөл, боломж, тэнцүү хугацаа ногдохоор тооцно.
- 3.5. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх сурталчилгааны цаг, хуваарийн төслийг Сонгуулийн ерөнхий хороо хуралдаанаараа хэлэлцэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 5-аас доошгүй хоногийн өмнө баталж, Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 3.6. Олон нийтийн радио, телевизээс бусад өргөн нэвтрүүлгийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг гаргахдаа

Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.6, 82.13, 82.16 дах хэсэгт заасан зарчмыг баримтлана.

- 3.7. Монгол Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, аймаг, нийслэлийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь тус бүр хоногт нэг цагаас илүүгүй байна.
- 3.8. Сонгуулийн сурталчилгаанд хуваарилсан эфирийн цагийг радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлагын 7.27, 7.29-т заасан зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.
- 3.9. Радио, телевиз нь Сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хориглосон нэвтрүүлэг, зар сурталчилгаа бэлтгэж, нэвтрүүлэхгүй байх үүрэгтэй.

Дөрөв. Сонгуулийн сурталчилгаанд тавих хяналт

- 4.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн тухай хууль болон энэхүү журамд заасны дагуу радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллах бөгөөд Харилцаа холбооны тухай хууль, Сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- 4.2. Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавихдаа Сонгуулийн тухай хуулийн 82.5, 82.6, 82.12, 82.13, 82.15, 82.16, 82.17 дахь заалтад заасан чиглэлээр болон энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллахдаа хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхэд хамааралгүй, агуулгатай холбоотой асуудлаар гомдол маргаан гарсан тохиолдолд холбогдох байгууллага-т мэдэгдэж, хяналт, мониторингийн бичлэгээр хангаж ажиллана.
- 4.4. Өргөн нэвтрүүлгийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн тухай тайлан мэдээллийг Зохицуулах хорооноос гаргасан маягт, зааврын дагуу гаргаж тухай бүр Зохицуулах хороонд цахимаар хүргүүлэх бөгөөд 7 хоногийн тайланг нэгтгэж, албан бичгээр баталгаажуулж хүргүүлнэ.
- 4.5. Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих ажлыг зохион байгуулж, хуульд заасан арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

- 4.6. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд эфирийн нийт цагийн бичлэгийг сурталчилгааны хоногоор хийж Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлнэ.
- 4.7. Хяналт тавихад ашиглаж байгаа мэдээ, мэдээллийг энэ журамд зааснаас өөр зорилгоор ашиглахгүй.
- 4.8. Энэ журмыг зөрчсөн нам, эвсэл, нэр дэвшигч, хэвлэл мэдээллийн байгууллагад Сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 4.9. Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь хяналтын дүн мэдээ, зөрчлийн талаар сонгуулийн сурталчилгааны үеэр олон нийтэд мэдээлнэ.

(Энэ журамд 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 176/38А дугаар хамтарсан тогтоол, 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 12/15 дугаар хамтарсан тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.)

---oOo---